



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

203.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 405	525
204.	Гадаадаас 2015 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай	Дугаар 2	528

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 405

Улаанбаатар  
хот

#### Журам шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 164 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**С.ЧИНЗОРИГ**



Засгийн газрын 2014 оны 405 дугаар  
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИД НЭГ УДААГИЙН  
БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэвэр тогтоолгосон төрийн жинхэнэ албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан төрийн тусгай албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгоход энэ журам үйлчлэхгүй.

3. Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэвэр тогтоолгосон төрийн жинхэнэ албан хаагчид хамгийн сүүлд хашиж байсан албан тушаалын нэг сарын үндсэн цалинг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоогоор жүржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

Тайлбар: Төрийн жинхэнэ албан хаагчийн хамгийн сүүлд хашиж байсан албан тушаалын нэг сарын үндсэн цалингийн хэмжээг тухайн албан хаагчийн сүүлийн гурван жилийн нэг сарын үндсэн цалингийн дунджаар тооцож тогтооно.

4. Төрийн жинхэнэ албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингаас ихгүй байна.

5. Төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулж тооцно:

5.1. Төрийн албаны тухай хуулийн 6-9 дүгээр зүйлд заасан албан тушаалд ажилласан хугацаа;

5.2. Улсын Их Хурлаас 1995 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан хугацаа;

5.3. улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтан (хөлсөөр түр ажиллагч орохгүй)-аар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа;



5.4. төрийн албанд ажиллаж байхдаа гурван сар хүртэл хугацаагаар мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, дахин мэргэших, шинээр мэргэжил эзэмшихээр суралцсан хугацаа;

5.5. төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний болон амаржсаны амралттай, хууль тогтоомжийн дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацаа;

5.6. төрийн байгууллагын дотоод журмын дагуу чөлөөтэй байсан хугацаа;

5.7. төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхээр эгүүлэн тогтоосон бол уг шалтгаанаар ажилгүй байсан хугацаа;

5.8. баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан, шүүхээс цагаатгах тогтоол гарсан, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйн улмаас эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус тогтоолыг хүчингүй болгосон бол төрийн жинхэнэ албан хаагчийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан хугацаа.

6. Төрийн албанд ажилласан хугацааг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж буюу албан тушаалтан тооцож тодорхойлно. Төрийн албанд ажилласан хугацааг хуанлийн бүтэн жилээр тооцно.

7. Төрийн албанд ажилласан хугацааг тооцох үндсэн бичиг баримт нь хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэр байна. Үндсэн бичиг баримтаа үрэгдүүлсэн төрийн албан хаагч архивын лавлагаа авна. Архивын лавлагаа авах боломжгүй бол төрийн албанд ажилласан хугацааг шүүхээр тогтоолгоно.

8. Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага жил бүр төсөвтөө тусгана.

9. Төрийн жинхэнэ албанд хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг нь хянаж үзсэний үндсэн дээр төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох асуудлыг шийдвэрлэнэ.

10. Өндөр насны тэтгэврээ албан ёсоор тогтоолгож, ажил олгогчид өргөдөл гаргасных нь дараа энэ журамд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 1 дүгээр  
сарын 7-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар  
хот

### **Гадаадаас 2015 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай**

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4, 7.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад 2015 онд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заагдаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь байхаар тогтоосугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллага нь 30-аас доош тооны гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн авах бол тухай бүр салбарын сайдын хүрээнд, 30-аас дээш бол Засгийн газарт асуудлыг тавьж шийдвэрлүүлж байхыг Хөдөлмөрийн сайд С.Чинзоригт үүрэг болгосугай.

4. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж байхыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамбад үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**С.ЧИНЗОРИГ**



Засгийн газрын 2015 оны 2 дугаар  
тогтоолын хавсралт

2015 ОНД АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ  
ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ХУВЬ

Салбар	Дэд салбар	Бүлэг	Анги	Тодорхойлолт	Нийт ажиллагчдын тоо						
					50 хүртэл	51-100	101-150	151-200	201-250	251-ээс дээш	
В	УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ										
	06			Түүхий газрын тос, байгалийн хийн олборлолт	60	70	70	75	75	75	75
	09	099	0990	Түүхий газрын тос, байгалийн хийн хайгуул	60	70	70	75	75	75	75
	09	099	0990	Уул уурхайн олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	20	25	25	25	25	25	25
С	БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР										
	10			Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	6	7	8	9	9	9
	13			Нэхмэлийн үйлдвэрлэл	5	6	7	8	9	9	9
	20			Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	8	9	10	11	12	12	12
	23			Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	5	9	10	12	13	15	15
	24			Металл үйлдвэрлэл	5	5	5	10	12	15	15
	32			Бусад боловсруулах үйлдвэрлэл	8	9	10	11	12	12	12

33			Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар үйлчилгээ	20	20	25	25	25	25	25
D	ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ			5	6	6	7	8	9	
E	УС ХАНГАМЖ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА			5	6	7	8	9	9	
F	БАРИЛГА									
	41	4100	Барилга угсралт	15	15	15	20	22	25	
			Уул уурхайн барилга угсралт	20	22	25	25	30	35	
	421	4210	Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	20	25	30	35	40	45	
G	БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ									
	45		Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	20	20	20	20	20	20	
H	ТЭЭВЭР БА АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА									
I	ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ									
	55		Зочид буудал, байр сууцаар үйлчлэх үйл ажиллагаа	5	5	5	10	10	10	
	56		Нийтийн хоолны үйлчилгээ	10	10	10	10	10	10	

М МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА										
72		Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны үйл ажиллагаа	30	30	30	30	30	30	30	30
N УДИРДЛАГЫН БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА										
	791	Аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын үйл ажиллагаа	10	15	20	20	20	25	25	25
P 85 БОЛОВСРОЛ										
	851, 852, 854	Бага болон бүрэн дунд, бусад боловсрол олгох үйл ажиллагаа	30	30	30	30	30	30	30	30
	853, 8522, 8530	Техник мэргэжлийн дунд боловсрол болон дээд боловсрол олгох үйл ажиллагаа	30	30	30	30	30	30	30	30
		Засгийн газар хоорондын гэрээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай, олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулдаг боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаа	70	70	70	70	80	80	80	80
Q ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БА НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА										
	86	Хүний эрүүл мэндийн үйл ажиллагаа	5	6	6	6	7	8	8	9
	87	Оршин суугчдад үзүүлэх халамжийн үйл ажиллагаа	5	10	15	15	15	20	20	20
R УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ										
90	900	Бүтээл туурвих, урлаг, үзвэр, үйлчилгээний үйл ажиллагаа	5	5	5	5	5	5	5	5

93		Спорт, зугаа цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа	5	5	5	5	5	5	5
S	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА								
95		Хувийн болон өрхийн хэрэглээний зориулалттай бараа, компьютерийн засвар, үйлчилгээ	5	6	6	7	7	8	9
96	960	Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5	6	6	7	7	8	9
U	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СҮҮРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА								
99	990 9900	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	40	40	40	40	40	40	40
		Гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөгчийн газар мөн хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын төрийн бус байгууллага	30	30	30	30	30	30	30

Жич: 20 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага нь 1 гадаадын иргэн ажиллуулж болно.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiiin\_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 14003